



# Музей судлал ба музейн мэргэжлийн ёс зүй

Д.Бумаа түүхийн ухааны доктор, дэд профессор  
Монголын Үндэсний Музей  
Музей судлалын мэргэжил арга зүйн төв

# АГУУЛГА

1. Музей судлал, бүтэц
2. Музейн ажлын арга зүй
3. Мэргэжлийн ёс зүй, мэргэжлийн ёс суртахууны тухай үндсэн ойлголт

Музей судлал нь гурван бүрэлдэхүүн хэсэгтэй. Үүнд:

- Түүх генетик - музей ба музейн ажил хэргийн түүх, бодит ертөнцийн эд зүйлийг сонгох, хадгалах ба ашиглах
- Онолын үндэс
- Хавсарга буюу хэрэглээний хэсэг: музейн ажлын шинжлэх ухааны арга зүй, арга техник, музейн үйл ажиллагааны удирдлага зохион байгуулалт

Музей судлалын бүтэц: (Дж. Льюис) онол ба практик хоёроос бүрдэнэ:

Онол:

- Ерөнхий онол (шинжлэх ухааны талаар ерөнхий ойлголт,
- Баримтжуулалт буюу иж бүрдүүлэлтийн онол: Музейн сан хөмрөгийг бүрдүүлэх, эд зүйлийг сонгож цуглуулах;
- Тезаврын онол - сан хөмрөгийн ажлын онол, үнэт зүйлийг судалж тодорхойлох, хадгалах, бүртгэх,
- Коммуникаци- харилцаа холбооны онол - мэдээллийг дамжуулах.

## **Практик**

(хавсарга -хэрэглээний музей судлал)


- Музейн ажлын арга зүй - гүйцэтгэх арга, хэрэглэх аргуудын багц
- Музейн ажлын арга техник
- Удирдлага зохион байгуулалтын арга зам - менежмент, маркетинг, зөвлөгөө - консалтинг)



- Хавсарга музей:

Музейн үйл ажиллагааны нийтлэг ба тусгай арга зүй, гүйцэтгэх арга гэж байна.

- Тоо бүртгэл ба хадгалалт
- Эд зүйлийг тодорхойлох ба шинжлэн магадлах
- Үзүүллэг зохион байгуулах

- 
- Музейн үндсэн ажлын арга зүй (сан хөмрөг, тоо бүртгэл, хадгалалт, судалгаа ба үзүүллэг дэглэлт):
  - Музейн ажлын арга техник - арга ажиллагаа нь арга зүйд үндэслэсэн практик үйл ажиллагааны арга хэрэгсэл юм.
  - Байнгын болон түр хадгалалтын бүртгэлийн баримт бичгийг бүрдүүлэх арга ажиллагаа, эрдэм шинжилгээний картуудыг бөглөх арга ажиллагаа, хадгалалтын арга ажиллагаа гм.

Музейн ажлын арга техник - арга ажиллагаа


-музейн барилгын төсөл гаргах,

- дэлгэж үзүүлэх ба мэдээлэл дамжуулах арга хэрэгсэл,

- эд зүйлийн физик хадгалалтын байдлыг судлах, бэхжүүлэх- консервация, сэргээн засварлалт - сэлбэн засах - реставрация),

Музейн мэргэжлийн ажил хэргийн зохион байгуулалт ба үйл ажиллагааны удирдлага (менежмент маркетинг).



- 
- Музейн сурвалж судлалын онолын хэсэг нь баримтжуулах ба судлан тодорхойлох онолд хамаарна.

Харин практик хэсэг нь хавсарга музей судлалд хамаарна.

- атрибуц - эд өлгийн зүйлийг тодорхойлох, дүрслэн бичих
- Экспертиз - шинжлэх

# Музейн сан хөмрөгийн ажлын үндсэн чиглэлүүд:

- Цуглуулах, иж бүрдүүлэх
- Бүртгэх баримтжуулах
- Хадгалах хамгаалах
- Судалгаа хийх
- Сурталчлах, түгээх

## Музейн цуглуулгатай ажиллах нь

- Цуглуулгын бүртгэл
- Цуглуулгын арчилгаа
- Цуглуулгын сэргээн засварлалт
- Цуглуулгын судалгаа

## • **Музейн эд зүйл**

- Музейн эд зүйлд бодит байдалд хүний хандах хандлага тусдаг. Энэ хандлагыг музей бий болгох хэрэгцээ гэнэ. Өөрөөр хэлбэл,
- Бодит байдал ертөнцийг тусгасан, утга агуулгатай, гоо зүйн мэдээллийн эх сурвалж болж чадах, гоо зүйн үнэ цэнэтэй эд зүйлийг хадгалж, нийгмээрээ ашиглах хэрэгцээ

## АРГА

- Музей судлал нь салбар хоорондын ба салбар дундын шинжлэх ухаан.
- Бусад шинжлэх ухааны мэдлэг, ойлголтуудын цогц ба аргыг бүтээлчээр ашигладаг. Харилцан холбогддог.
- Гүн ухаанч хандлага нь музейн концепцийг бий болгох онол арга зүй, үйл ажиллагааны талуудыг тайлбарлах, цуглуулгын түүх соёлын үнэ цэнийг интерпретаци хийх
-

## Гносеология - мэдлэгийн онол

- Музейн эд зүйл нь археологи, угсаатны зүй зэрэг шинжлэх ухааны сурвалж болохоосоо илүүтэй илүү өргөн хүрээтэй, нэгтгэсэн харилцааг тээгч болдог.


Аксиология - бодит байдалд үнэлгээ өгч, сонголттой хандах, үнэлэх, эд зүйлийг сонгох

Психология - ерөнхий сэтгэл зүй ба хувь хүний сэтгэл зүйн арга хэрэгслээр эд зүйлд агуулагдсан мэдээллийг хүлээн авч буй байдлыг судлах

- Сурган хүмүүжүүлэх ухаан ба социологийн шинжлэх ухаанд музейн боловсрол хүмүүжлийн чиг үүргээ хэрэгжүүлэх арга зүй ба арга үндэслэдэг.
- Ёс зүйн шинжлэх ухаан:
  - Үзүүллэг, үзэсгэлэн
  - музейн сурган ба амралт чөлөөт цагийн хөтөлбөрөөр цуглуулгыг тайлбарлах явдал нь ёс зүйн үнэлгээ, ёс суртахуун үнэт зүйлийн чиг баримжаа ба учир шалтгаан, үндэслэл дээр тулгуурладаг.

- ХХ зууны сүүлчээр музей судлалд өөрчлөлт орсон . Энэ нь хувь хүний соёл иргэншил, нийгэм ба гэр бүлтэйгээ харилцан холбогдох олон талын харилцаа холбоог судлах гүн ухааны үзэл бодол орж ирсэнтэй холбоотой. Үзэгдэлд цогц хандах хандлага
- Түүх, соёл судлал, урлаг судлал, утга зохиол судлал ба хэл шинжлэлийн шинжлэх ухааны арга зүйн зарчмуудыг ашиглаж, музей судлалын нийгэм - хүмүүнлэгийн үндэслэлийг бий болгоход музей судлалын олон шинжлэх






XXI зуунд музей судлал нь музейн эд зүйлийг хүмүүнлэгийн үүднээс танин мэдэх процесс.

Музейн эд зүйл нь хүн, хүний үйл ажиллагааны үр дүнд материаллаг, оюун санаа, нийгэм, сэтгэл судлал, соёл судлал ба байгалийн бүрэлдэхүүн хэсгүүдийн харилцан холбоог илэрхийлж байдаг.

Социологи, намтар судлал, нийгмийн сэтгэл зүй, герменевтикийн аргыг хэрэглэнэ.

## Соёл судлалын хандлага нь

- Музейн эд зүйл бүтээгдсэн нөхцөл байдал, зорилго
- Тухайн соёлын агуулга дахь ач холбогдол
- Түүнийг бие болгосон бодит байдлын үүднээс ямар ач холбогдолтой гэдгийг судална.

- 
- Тодорхой цаг үеийн байгаль нийгэмд эд зүйл ямар үүрэг гүйцэтгэсэн тухай судлахад их анхаардаг.
  - Үүний тулд эд зүйл, илэрхийлж буй үзэгдэл, үйл явцын утга зүйг тодруулна.

## Наад захын шаардлагууд ба мэргэжлийн ёс зүй

- Музейн ажлын зорилго нь нийгэмд үйлчлэх явдал тул мэргэжлийн хамгийн өндөр түвшинд үйл ажиллагаа явуулах ёстой байдаг. ОУМЗ өөрийн ёс зүйн дүрэм журмыг тодорхойлохдоо наад захын шаардлагын түвшинг тогтоодог.
- Энэ стандартыг музейн ажлын чанарын түвшинг тодорхойлоход хэрэглэнэ. Мөн орон нутгийн эрэлт хэрэгцээ ба тодорхой чиглэлийн музейн ажилтнуудад тавигдах шаардлагыг хангахуйцаар тогтоож болно.

- Музейн үйлчилгээг үр өгөөжтэй үзүүлэхийн тулд олон нийтийн итгэлийг хүлээх хэрэгтэй.
- Музейн бүх ажилтнууд (орон нутаг ба улсын түвшинд ажиллаж, дэлхий дахины материаллаг ба материаллаг бус ямарваа нэгэн соёлын өвийн хадгалалт хамгаалалтыг хариуцдаг) энэхүү итгэлийг бэхжүүлэхэд үйлсэд хувь нэмрээ оруулж байх үүрэгтэй.
- Үүнд музейн талаарх олон нийтийн бодол санааг бүрдүүлэх, музейн үүрэг зорилго ба удирдлагын талаар тайлбарлан ярих замаар хүрнэ.

## Ёс зүй

Ёс суртахууныг судалдаг ухаан буюу хүний зөв амьдралын тухай ухаан, хүний мэдлэг оюуны салбар гэж үзэж болох юм.

- Нийгэмд хүмүүс хэрхэн биеэ авч явах талаар олон хэм хэмжээнүүд үйлчилдэг. Тухайлбал, хууль эрх зүйн хэм хэмжээ, ёс суртахууны хэм хэмжээ, соёл зан заншлын хэм хэмжээ, гоо зүйн хэм хэмжээ, шашны хэм хэмжээ гээд олон арван дүрэм, горим үйлчилдэг байна. Хүний амьдралын энэхүү олон дүрэм, горим дотроос нийгэмд гүйцэтгэх үүрэг, байр сууриараа ёс зүйн хэм хэмжээ онцгой ялгардаг.

## **Мэргэжлийн ёс зүй, мэргэжлийн ёс суртахууны тухай үндсэн ойлголт**

- Хүн төрөлхтөний хөгжлийн явцад таван мянга гаруй мэргэжил бий болжээ. Тухайн ажлыг хийж гүйцэтгэх арга ухаан, ур чадвар, мэдлэг мэргэжил, дадлага туршлага, үүрэг хариуцлага, шаардлага зэргээрээ мэргэжил бүр ялгаатай. Эндээс мэргэжлийн ёс зүйн асуудлууд урган гарч ирнэ.

- Мэргэжлийн үйл ажиллагааг хэрэгжүүлэхэд

- 1) ерөнхий ёс зүй


- 2) мэргэжлийн ёс зүй гэсэн ёс үндсэн хоёр төрөл үйлчилнэ.

Аливаа мэргэжилтэн хувь хүн талаасаа ерөнхий ёс зүйн зарчмуудыг баримтлах ёстой байдаг бол, тухайн мэргэжлийн онцлогоос шалтгаалж мэргэжлийн ёс зүйн зарчмуудыг баримтлах хэрэгтэй болно.

Мэргэжлийн ёс зүйн дүрэм журам нь ерөнхий ёс зүйн дүрэм журамтай харьцуулбал тодорхой нөхцөл байдалд үүсэн бий болсон асуудлыг хэрхэн шийдвэрлэх талаар илүү тодорхой хариулт өгч чадна.



- Мэргэжлийн ёс зүйн дүрэм журам нь аливаа үйлдлийн талаар хатуу тогтоогдсон дэг журам, түүнийг биелүүлэх арга зам, хэм хэмжээг тогтоож өгдөг.
- Ёс суртахуунлаг ажилтан, албан хаагчидтай байгууллагын үйлчлүүлэгчид, харилцагчдын итгэх итгэл өндөр байдаг бөгөөд байгууллага хамт олон ч өөдлөн дэвжих, тогтвортой оршин тогтнох, ирээдүйд итгэл төгс ажиллаж амьдрах боломж бүрдэнэ.



Мэргэжлийн ёс зүй гэдэг ойлголт тухайн мэргэжлийн хүний нийгэм болон өөрийн мэргэжил нэгт нөхдийн өмнө хүлээх хариуцлагатай холбогдоно.

Эзэмшсэн мэргэжлийнхээ үүргийг тухайн хүн хир зэрэг гүйцэтгэж байгаагаас мэргэжлийн нэр төр, мэргэжлийн нэр хүнд шалтгаална.

Ёс зүй нь үүрэг хариуцлага, түүнийг биелүүлэх ухамсар, нэр төрийг нэгэн адил агуулсан ухагдахуун бөгөөд ёс зүйн тусламжаар өөрийн ажил хөдөлмөрийн үр дүнг үзэж, бэрхшээлийг даван туулж, нийгмийн өмнө хүлээсэн үүргээ биелүүлж байдаг.

Мэргэжил бүхэнд тохирсон мэргэжлийн ур чадвар, өвөрмөц харилцаа шаардагдана.

- Мэргэжлийн ёс зүй нь тухайн салбар болон мэргэжлийн хүмүүсийн дагаж мөрдөх хэм хэмжээ, ёс журам, үг хэллэг, хувцаслалт, харилцааны соёл зэрэг мэргэжлийн онцлогийг цогц байдлаар тусган харуулдаг ойлголт юм. Үүнд:

1. онолын мэдлэг
2. нэр хүнд
3. нийгмийн дэмжлэг,
4. зан үйлийн ёс зүйн дүрэм
5. мэргэжлийн соёл гэсэн таван үндсэн мөн чанарт хуваан авч үздэг.

# Мэргэжлийн онолын мэдлэг:

-орчин үед мэргэжил нь мэдлэгт, өөрөөр хэлбэл дадал дүйг практик үйл ажиллагаанд хөгжүүлэх боломж бүрдүүлэгч онолын үндэслэлд суурилдаг гэж үзэж байна.

- Мэргэжлийн нэр хүнд:

-үйлчлүүлэгчид мэргэжилтний мэдлэг, туршлагад найдаж, зөвхөн түүний үйлчилгээг хүртэхийг урьтал болгодог нь уг мэргэжлийн нэр хүндийг бататган өргөж, үзэл баримтлалыг улам “давуутай”, дархан эрхтэй “болгож байдаг.

- Нийгмийн дэмжлэг

-мэргэжилтнийг шалгаруулалтад оруулах, шалгалт өгүүлэх, магадлан итгэмжлэх нөхцөл зэргийг тогтоож, мөрдүүлэх эрх, тухайлан авч үзэж буй үйл ажиллагааны хүрээнд эдийн засгийн давуу байдлыг болон удирдлага зохион байгуулалтын бодлого, стандартыг тодорхойлж нэвтрүүлэх эрх олгох зэргээр тухайн мэргэжлийг нийгмийн зүгээс дэмжин дэмжлэг үзүүлнэ.

- **Зан үйлийн ёс зүйн дүрэм:**

- Мэргэжил нь олон зүйлийн эрх дарх эдэлдэг учраас “дархлагдсан эрхээ хортойгоор ашиглах, энэхүү эрх мэдэл, эрх дархаа нийгмийн ашиг сонирхлоос дээгүүр тавьж зөвхөн хувийн эрх ашгаа хамгаалахад ашиглах” гэсэн аюул хэзээ ямагт нүүрлэж байдаг.
- Тиймээс мэргэжил бүр нийгмийн хяналтыг хангах үүднээс гишүүдийнхээ зан үйлийн горимыг тодорхойлж чадахуйц ёс зүйн дүрэм боловсруулж мөрдсөнөөр үйлчлүүлэгч ба мэргэжилтэн хоорондын, мэргэжилтэн ба нийгэм хоорондын харилцааг зохицуулдаг.
- Энэхүү ёс зүйн дүрэм нь мэргэжилтнүүдэд сахилга хариуцлагын тодорхой журам мөрдүүлдэг учир “тэдний үйлдлийг шүүмжлэн засах, хянан шалгах, болохгүй бол дуулгаваргүй гишүүдийг үлдэн хөөх” зэрэг боломж бүрдүүлдэг. Энэ нь эцсийн дүндээ мэргэжлийн нэр хүндийг бэхжүүлэхэд чиглэсэн арга хэмжээ юм.

## Мэргэжлийн соёл

- Мэргэжлийн соёлд тавигдах шаардлагыг хэрэгжүүлснээр мэргэжлийн нэр хүндийг дэмжиж байдаг. Аливаа мэргэжил нь нийгэмд тодорхой үнэ цэнэтэй, зан үйлийн тогтсон хэм хэмжээ ба утгын томъёолсон тэмдэг бүхий албан ёсны болон албан ёсны бус хэсэг бүлэг хүмүүс хоорондын харилцан үйлдлээр хэрэгжиж байдаг.
- Мэргэжлийн аливаа байгууллагын гишүүд мэргэжилдээ үнэнч байж, ажилдаа хүч чадал, авьяас билэг, эрдэм ухаанаа бүрэн зориулснаар ажил мэргэжлээрээ ахиу байр сууринд дэвших эрмэлзэл биелнэ. Энэ нь мэргэжлийн соёлын нэгэн бүрдэл хэсэг юм.



# **Анхаарал тавьсанд баярлалаа**

2017.05.29.